- “Ì î íãîëûí ìýäýý” Ì î íãîëûí ò¿¿õèéã áè÷íý -

# Ì Î Í Ã Î Ë Û Í ìýäýý

20 Anniversary

Õ¿í àì 3,209.513...
ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2018.06.12. Мягмар. №116 (4966) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

www.dardas.mn
facebook.com/dardas.mn
twitter.com/MMdardas
mongoliinmedeesonin@gmail.com

- “Дэлхийн сонины холбоо”-ны гишүүн
- 1999 оны шилдэг чөлөөт хэвлэл
- 2002 оны шилдэг хэвлэл
- 2013 оны Монгол Улсын шилдэг сонин
- Best of Mongolia-2016 - Оны шилдэг сонин

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




20 дахь жилдээ Дугаарыг эрхэлсэн Баттөрийн ДАВААХҮҮ

## ДОТОР НҮҮРТ

II Í¯¯ðò:

Õªªðõªí òèéí ХӨНДИЙН ҮНЭН ТӨРХ “ГЭРЭЛТ ГУДАМЖ”

...“Бид баасан гарагаас даваа гараг хүртэл байнгын түгшүүртэй байдаг. Гэрэлт гудамжны замыг хааснаас болж түргэний машин хойд хаалгаар ирж чадахаа больсон. Түргэний машин замын хашилтыг тойрч ирэх гэж цаг хугацаа алдаж байгаа...

VIII Í¯¯ðò:

“БУРУУ ЗАМААР БУДАА ТЭЭВЭЛ БУЦАХДАА ШОРОО ТЭЭНЭ”

БАРИМТ & ТАЙЛБАР



# “БОГД АР” ХОРООЛЛЫН сургууль, цэцэрлэгийн газрын захирамжийг ГУРВАН УДАА ӨӨРЧИЛЖЭЭ

С.БУДРАГЧАА
budragchaas@gmail.com

Баянгол дүүргийн нэгдүгээр хорооны нутаг дэвсгэрт 2001 онд “Богд Ар” хорооллын барилгын ажил эхэлж байжээ. Анх 1088 айлын орон сууцны барилга, 640 хүүхдийн цэцэрлэг, 240 хүүхдийн цэцэрлэг, хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн байр нийгмийн бүх үйлчилгээг цогцоор нь шийдвэрлэсэн Улаанбаатар хотын жишиг хороолол болно хэмээн яригдаж байсан уг төсөл өнөөдөр хотын төвд байрлах хамгийн “дампуу” хорооллоор нэрлэгдээд байгаа юм.

¯ðãýëæëýë íü IV í¿¿ðò

ХӨНДӨХ СЭДЭВ

## Үндсэн хуулийн цэцийн бүрэлдэхүүн хэнд таалагдах ёстой вэ

А.СЭРГЭЛЭН

Өнгөрсөн сард Үндсэн хуулийн цэцийн гишүүдэд нэр дэвшигчдийг УИХ-аар нэлээд дуулиантай хэлэлцэж томилсноос хойш тодорхой ашиг сонирхлын бүлгийн зүгээс эл томилгооны эсрэг махинаци өрнүүлж эхэлсэн нь илт анзаарагдах боллоо. Ер нь Үндсэн хуулийн цэцийн гишүүдийг яагаад “солих” болов гэдгийг эхлээд эргэн саная. Зарим нэг хуульчдын хэлж байгаа шиг Ерөнхийлөгч Х.Баттулга ҮХЦ-ийг өөрийн “харьяалалд” оруулчихаад байгаа хэрэг үү. Яагаад хэсэг хуульч УИХ-аас хэлэлцэж хийсэн томилгоог эсэргүүцээд эхлэв гээд тодруулвал зохих зүйл олон байна. Үндсэн хуулийн цэцийн гишүүн асан Н.Жанцан, Д.Наранчимэг, Т.Лхагваа, Д.Сугар нарын бүрэн эрхийн хугацаа дуусан юм.

¯ðãýëæëýë íü III í¿¿ðò

ҮЗЭЛ БОДОЛ

## Тэд хөг ЖИЛ, бид “хөн ЖИЛ” ярьсаар...

Б.ӨНӨРТОГТОХ
baljirunurtogtokh@gmail.com

УИХ-ын эмэгтэй гишүүд өчигдөр Төрийн ордонд мэдээлэл хийж, “Хүчингийн хэрэгт холбогдсон улстөрчөө хамгаалж үлдсэн парламентаас ичиж байна” хэмээв. Улс орны нэн чухал хуулийн төслүүд олон байхад УИХ нь “улаан мах”-ны хэрэг шүүж, бүр улс орон даяар шууд гаргаж суугааг хараад улстөрч эмэгтэйчүүд байтугай монголчууд тэр чигтээ ичиж үхэх шахлаа. Дэлхий дахинд улс орноороо шившиг болж дуусав. Угтаа ийм балай юманд оролцохгүй хэмээн орхиж гарсан М.Оюунчимэг гишүүний ч буруутгаад байх шаардлага алга. Тэд ичиж бас зэвүүцсэн учраас л ийм хандлага гаргасан хэрэг биз. Ийм гутамшигтай үйл явдал олон битгий тохиолдоосой хэмээн залбирч, чөлөөлөгдөх өргөдлөө өгсөн Д.Гантулгад баярлаж суухаас өөр яалтай. Бид тусгаар тогтносон, бүрэн эрхээрээ тун ч гайхуулах дуртай. Хэдхэн өдрийн өмнө ШХАБ-д элсэх тухай яриа санаатай, санамсаргүй гарч эхлэхэд л “стан” орнуудтай ижил биш, бид бол тусгаар улс гэх мэтээр дөвчигнөлөө.

¯ðãýëæëýë íü III í¿¿ðò

RUSSIA-2018

# ОХУ Хөлбөмбөгийн ДАШТ-д бэлэн



Б.ДАВААХҮҮ
Davaakhuu0128@gmail.com

Хөлбөмбөгийн ДАШТ хоёр өдрийн дараа ОХУ-д эхэлнэ. Манай хойд хөрш дэлхийн хүчирхэг нэгэн гүрэн боловч, Хөлбөмбөгийн ДАШТ зохион байгуулах эрхийг анх удаагаа авсан нь энэ юм.

¯ðãýëæëýë íü VII í¿¿ðò

DAISO JAPAN

Амьдралыг амттай болгоё

БҮХ БАРААА 3500₮ 5500₮ 7500₮ 9500₮

Daiso-Шарга салбараар үйлчлүүлэх дуртай хамт олон нь найрсаг, түргэн үйлчилдэг. Маш чамин хөөрхөн бараануудыг зардаг шүү.

Customer Voice

Хороллын Тумбаш дэлгүүрийн баруун талд Эв плаза Шарга дэлгүүр

Утас: 94018548